



138

УЛААНБААТАР
ХОТЫН ХӨДӨЛМӨРЧДИЙН ДЕПУТАТУУДЫН
ХҮРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ШИЙДВЭР

195 5 оны 5 дугаар сарын 26

Дугаар 76 Хот

Хотын биеийн тамир спортын хэргийг
эрхлэх хорооны түр дүрмийг батлах
тухай.

Улаанбаатар хотын Х.Д.Х.Гүйцэтгэх захиргааны
гшүүдийн хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Улсын биеийн тамирын хорооноос зөвшөөрсөнийг үндэслэн хотын биеийн тамирын Спортын хэргийг эрхлэх хорооны түр дүрмийг баталсугай.
2. Энэхүү ~~сөрөг~~ ^{дөрмөн} дүрмийг практик ажиллагаа дээр зөвөөр хэрэгжүүлэн биелүүлэхийг хотын биеийн тамирын хороонд үүрэг болгосугай.

ХОТЫН Х.Д.Х.ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРГААНЫ ДАРГА

ХАРИУУЛАГЧИЙН НАРИЙН

БИЧГЭГЧ ДАРГА

"БАГЛА"

"НАЙДАНЖАВ"

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ХЭРГИЙГ ЭРХЛЭХ ХОРООНЫ ТҮР ДҮРЭМ.

нэг. Ерөнхий анги.

а. Биеийн тамир спортын хэргийг эрхлэх Улаанбаатар хотын хороо нь нийслэлийн хэмжээнд биеийн тамир спортыг олон нийтийн хөдөлгөөн болгон хөгжүүлэхэд өөрийн бүх ажиллагааг чиглүүлэн зохионо.

б. Хотын биеийн тамирын спортын хэргийг эрхлэх хороо нь улсын Б.Т.С.Х.Э. хороо, Улаанбаатар хотын Х.Д.Х.Г.Захиргаанд шууд удирдуулан ажлаа тэйдэгнэж байна.

в. Улаанбаатар хотын биеийн тамирын хорооны бүх ажлыг тус хорооны дарга шууд удирдаж, улсын Б.Т.С.Х.Э. хороо ба Улаанбаатар хотын Х.Д.Х.Г.захиргааны өмнө хариуцана.

хоёр: Тус хорооны зорилго.

а. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд биеийн тамир, спортын хөдөлгөөнийг зохион байгуулж удирдана.

б. Аугаа их Б.Х.Улсын спортын баялаг туршлагыг нийслэлийн тамирчдын дунд дэлгэрүүлэх ажлыг зохиох.

в. Биеийн тамир - спортын боловсон хүчнийг төртүлэн бэлтгэх ажлыг хотын хэмжээнд удирдан зохион байгуулна.

г. Нийслэлийн тамирчдын мөрөгжил, чадварыг дээшлүүлэх зорилгоор курс, семинарыг зохион байгуулах ба түүний программыг боловсруулж гаргана.

гурав. Тус хорооны эрх ба үүрэг.

а. С.С.Д. нийгэмлэгүүдийн ажилд туслах зорилгоор коллективүүдийн ажлыг шалгаж эцэг дүүдүгчид дээр эзэвэр зөвлөгөө өгч байх.

б. Нийслэлийн хэмжээнд байгаа сургууль үйлдвэр, албан байгууллага С.С.Д. нийгэмлэгүүдийн спортын бэйр талбай ажлыг хэрэгтэй цэгт хэлэлцэн тохирох үндсэн дээр авч ашиглана.

в. Улаанбаатар хотын дотор зохиогдох спортын ажлыг төлөвлөгөөжүүлэн уралдаан тэмцээний график календаруудыг боловсруулан гаргаж биелүүлэх.

г. Нийслэлийн тэргүүн тамирчдыг шалгаруулах уралдаан тэмцээнийг зохион явуулж тэр төрлүүдэд хотын аврага рекорд цолуудыг олгоно.

д. Спортын тэргүүний байгууллага, тамирчид, камондууд идэвхтэнүүдийг хотын хорооны деплом, кубока, сайшаалын үнэмлэхээр шагнах шийдвэрийг гаргаж уул шагналыг олгоно.

е. Спортын төрлүүдээр улсын зэрэгт тамирчдыг төрүүлэх зорилгоор баяр ёслол, амралтын өдрүүдээр уралдаан, тэмцээн, уулзалт үдэшлэгүүдийг өргөнөөр зохиож, улсаас тогтоосон нормыг биелүүлэгчидэд спортын мастер 1.2.3-р улсын зэрэг олгох саналыг улсын Б.Т.С.Х.Э. хороонд оруулж байх.

ё. Х.Б.Х.Вү гэдэг биеийн тамирын тэмдэгийн нормыг гүйцэтгүүлэх ажлыг нийгэмлэг коллективүүдээс хотын хэмжээнд зохиож байгаа ажил дээр хяналтыг тавьж шаардах ба биелүүлэх талаар ажил зохиох.

ж. Улаанбаатар хотын нэрэмжит камондуудыг нийслэлийн тэргүүний тамирчдаар зохион байгуулан ажиллуулах эрхээр хангагдана.

з. Тус хороо нь М.Х.Э.Эвлэлийн хотын хороо ба М.Ү.Эвлэлийн хотын зөвлөл, С.С.Д. нийгэмлэгүүд, эмэгтэйчүүд зэрэг бусад газруудтай өдөр тутамын нягт холбоотой ажиллан, тэдний дэмжлэг туслалцааг байнга авч ажиллах үүрэгтэй.

дөрөв. Тус хорооны зохион байгуулалт:

а. Нийслэл Улаанбаатар хотын Б.Т.С.Х. Э. хороо нь Улаанбаатар хотын Х.Д.Х.Г. захиргааны гишүүдийн хуралдаанаар

батлагдсан хорооны дарга ба гишүүдээр бүрэлдэнэ.

б. Тус хорооны ажиллах орон тооны бүрэлдүүнд хорооны даргаас гадна ажил төрлийн хоёр байцаагч тус тусын ажилын хувиар заагтай байна. үүнд:

1. Зохион байгуулалт:
2. Спортын ажлуудыг хариуцах чиглэлтэй ажиллана.

в. Нийслэл Улаанбаатар хотын Х.Д.Х.Г.Захиргааны дэрэг дэх Улаанбаатар хотын биеийн тамир спортын хэргийг эрхлэх хороо нь өөрийн агууллагыг хадгалсан тэмдэг ба бичгийн нүүртэй байна.

г. Улаанбаатар хотын Х.Д.Х.Гүйцэтгэх захиргааны дэрэгдэх биеийн тамир спортын хэргийг эрхлэх хотын хороо нь хотын төсөвтэй гүйцэтгэх захиргааны хангамжаар ажиллана.

Энэхүү түр дүрмийг Хотын Х.Д.Х. гүйцэтгэх захиргааны гишүүдийн 76-р шийдвэрээр батлав.

1955 оны 5-р сарын 26-ны өдөр: